

НИЙСЛЭЛИЙН НЙИТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН 2023 ОНД АЖИЛТАН, АЛБАН ХААГЧДАД  
ЗОХИОН БАЙГУУЛАХ СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ

Улаанбаатар хот

№	Сургалтын сэдэв	Хэрэгжилтийн биелэлт	Хэрэгжилт ийн хувь
1	2	3	4
Нэг. Мэргэшсэн, чадварлаг, тогтвортой төрийн албыг бэхжүүлэх, ажил мэргэжлийн чиглэлээр мэдлэг, чадварыг дээшлүүлэх чиглэлээр			
1	ISO 9001:2015 Чанарын удирдлагын тогтолцоо	Чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх ажлын хүрээнд 2023.03.07-ны өдөр НЗЗ-ны 5 дугаар байрны Иргэний танхимд байгууллагын нийт ажилтнуудад стандартын мэдлэг олгох сургалтыг Зөвлөх багш Б.Анхзаяа мэдээлэл арга зүйгээр ханган ажилласан. Тус ажлын хүрээнд нийт 8 бүлэг хичээлийн 10 багц сургалтад давхцсан тоогоор 302 ажилтан, албан хаагчийг хамруулан зохион байгуулсан. 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдөр "ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцоо" нэвтрүүлэх ажлын хүрээнд аудитор бэлтгэх сургалтад 5 албан хаагч хамрагдаж сертификат гардан авсан.	100%
2	Стандартын мэдлэг олгох	Мөн тус ажлын хүрээнд ажлын хэсгийн нарийн бичгийн дарга Г. Галбадрах 2023.3.20-ны өдрөөс 3.25-ны хооронд НЗЗ-ны 14 байранд ажиллаж байгаа төрийн үйлчилгээний албан хаагчдад стандартын мэдлэг ойлголт олгох сургалтын хуваарь гаргаж сургалтыг зохион байгуулсан. Сургалтад 125 төрийн албан хаагчид хамрагдсан.	100%
3	Стратеги, төлөвлөгөө боловсруулах арга зүй	Засгийн газрын 2020 оны 216-р тогтоол, ЗГХЭГ-ын даргын 100-р тушаалыг тус тус үндэслэн байгууллагын стратеги төлөвлөгөөг боловсруулахад шаардлагатай гадаад, дотоод орчныг задлан шинжилж, хэтийн зорилгыг тодорхойлохоор менежментийн зөвлөх сургалтыг Удирдлагын академитай хамтран "Стратеги төлөвлөгөө боловсруулах, арга зүй" сэдэвт сургалтад 2023 оны 03 дугаар сарын 09-ний өдөр нийт 4 албан хаагч хамрагдсан.	100%
4	Баримт бичгийн стандарт баримт, бичгийг зохион бүрдүүлэх,	Нийслэлийн Засаг даргын тамгын газрын Хүний нөөцийн хөгжлийн төвөөс ННЗБ-ын төрийн албанд анх томилогдсон албан хаагчид болон шинэ томилогдсон архив, бичиг хэргийн ажилтнуудад баримт	100%

1	2	3	4
		бичгийн стандарт, журмын дагуу бүрдүүлэх мэдлэг олгох “Баримт бичгийн стандарт баримт, бичгийг зохион бүрдүүлэх” сэдэвт сургалтад 2023 оны 03 дугаар сарын 23 болон 05 дугаар сарын 11-ний өдрүүдэд нийт 15 ажилтан, албан хаагчийг хамруулан зохион байгуулсан.	
5	“Алсын хараа-2050”	Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдөр зохион байгуулсан “Алсын хараа-2050” сургалтад идэвхтэй хамрагдаж 6 албан хаагч 100 хувийн ирцтэйгээр цахим шалгалтад тэнцэн сертификат гардан авсан. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн хөгжлийн төвөөс нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчдын чадавхыг бэхжүүлэх хөтөлбөрийн хүрээнд албан хаагчдад хөгжлийн бодлогын баримт бичгийн талаар ойлголтыг өгөх, бодлогын баримт бичиг боловсруулах, арга аргачлалд сургах, чадавхжуулах зорилготойгоор “Хөгжлийн бодлогын баримт бичгийн төлөвлөлт, тайлагналт хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй” сэдэвт сургалтад 2023 оны 09 дүгээр сарын 5,7-ны өдрүүдэд нийт 16 цагийн сургалтад 16 албан хаагч хамрагдсанаас 11 алба хаагч сертификат гардан авсан.	100%
6	Монгол хэлний зөв бичих дүрэм, албан хэрэгцээнд ашиглах	Монгол хэлний тухай хуулийн 24.2-т 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн Монгол бичгийн үндэсний хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлж, бэлтгэл хангасны үндсэн дээр төрийн болон орон нутгийн өөрөө удирдах байгууллага албан хэргээ крилл болон үндэсний бичгээр хөтөлнө гэсэн заалтыг хэрэгжүүлэх бэлтгэх ажлыг хангах хүрээнд монгол бичгийн анхан шатны мэдлэг олгох сургалтыг 2023 оны 08 дугаар сарын 30, 09 дүгээр сарын 14-ний өдрүүдэд Нийтлэг үйлчилгээний газрын байр хариуцсан менежер Б.Мөнхцэцэг нь монгол хэл бичгийн багшлах эрхтэй багштай тул Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн 50 албан хаагчдад нийт 14 цагийн хичээл заахаар төлөвлөснөөс 2 цагийн танхим, 6 цагийн цахим хичээлийг зохион байгуулан, мэдээлэл арга зүйгээр ханган ажиллалаа.	80%
7	Ажлын байрны үр дүнтэй харилцааг удирдан манлайлах нь Сэтгэл хөдлөлийн чадамжийг хөгжүүлэн ашиглах нь	Хүний нөөц хөгжлийн төв болон Австрали Tale Queensland хамтран байгууллагын баг хамт олны хооронд үр дүнтэй харилцааг бий болгох, зөрчилдөөн болон асуудлыг шийдвэрлэхэд ашигладаг үлгэрлэн манлайлах ур чадвар, туршлагаа харилцан солилцох боломжийг төрийн албан хаагчдад олгох зорилгоор 2023 оны 06	100%

1	2	3	4
		дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулсан “Ажлын байрны үр дүнтэй харилцааг удирдан манлайлах нь Сэтгэл хөдлөлийн чадамжийг хөгжүүлэн ашиглах нь” сэдэвт сургалтад 4 албан хаагч хамрагдсан.	
8	Хөдөлмөрийн тухай хуулийн сургалт	Нийслэл Улаанбаатар хотын Үйлдвэрчний эвлэлүүдийн холбооноос Нийтлэг үйлчилгээний газрын Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн нийт 32 албан хаагчдад 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр “Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Эвлэлдэн нэгдэх эрх ба Хамтын гэрээ байгуулахын давуу тал, ач холбогдол” сэдвийн хүрээнд нийт 4 цагийн багц хичээлийг Нийслэл УБ хотын ҮЭ-үүдийн Холбооны хуульч М.Цэнгэлбат, Нийслэл УБ хотын ҮЭ-үүдийн холбооны эрх зүйч Д.Отгонтуяа, МҮЭХ-ны арга зүйч багш Д.Гэнэндулам нар мэдээлэл арга зүйгээр ханган ажиллалаа.	100%
9	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх суурь мэдлэг олгох сургалт	“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх суурь мэдлэг олгох Худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх АЗ сургалтад Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газраас 2023 оны 11 дүгээр сарын 20-ноос 22-ний өдрүүдэд нийт 7 албан хаагч хамрагдаж, 6 албан хаагч шалгалтандаа тэнцэж сертификат гардан авсан.	
Хоёр. Шударга ёсыг эрхэмлэн бэхжүүлэх замаар ёс зүй, хувь хүний харилцаа хандлагыг дээшлүүлэх чиглэлээр:			
10	Ээлтэй орчин бүрдүүлэх нь сэдэвт сургалт	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газраас “Ээлтэй орчин бүрдүүлэх нь” сэдэвт сургалтыг 2023 оны 03 дугаар сарын 14-ний өдөр Байр хариуцсан менежерүүд, Угтах үйлчилгээний ажилтнуудыг хамруулан зохион байгуулсан. Сургалтын үеэр Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дарга Б.Амаржаргал нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй үйлчилгээг үзүүлэх, орчин бүрдүүлэхэд шаардлагатай туслах хэрэгсэл болох 4 ш тэргэнцрийг хүлээн авч НЗЗ-ны байруудад байршуулан үйлчилгээнд нэвтрүүлсэн.	100%
11	Авлигын эсрэг хууль, тогтоомжийн хэрэгжилт, авлигын хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ	Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 49 дугаар тогтоолоор 2023-2024 оныг авлигатай тэмцэх жил болгон зарласантай холбогдуулан 2023 оны 05 сарын 01-ний өдрөөс 06 сарын 01-ний өдөр хүртэл 1 сарын хугацаатай “Би өгөхгүй, авахгүй” нөлөөллийн аяныг Нийслэлийн Засаг захиргааны I,II,III,IV,Va,Vбв, Нийслэлийн төр захиргааны цогцолбор байр, Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв	100%

1	2	3	4
		<p>Драгон, Дүнжингарав, Мишээл салбар, Баянхошуу, Сэлбэ дэд төвийн 12 байршилд зохион байгууллаа. Аяны хүрээнд байгууллагын нийт 274 албан хаагчдад авлигын хор уршиг, сөрөг нөлөөлөл мөн урьдчилан сэргийлэх талаарх сургалтыг зохион байгуулж, мэдээ мэдээллээр хангасан. Мөн тухайн байруудад үйл ажиллагаа явуулж буй Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагийн алба хаагчид, үйлчилгээ авч буй иргэдэд Авлигын эсрэг үйл ажиллагааг сурталчлах зорилготойгоор авлигын эсрэг гарын авлага, сурталчилгааны зурагт хуудас, бусад материалуудыг тараах ажлыг зохион байгуулан ажиллалаа.</p>	
12	<p>Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар мэдлэг олгох</p>	<p>Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Хар тамхитай тэмцэх газраас “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтыг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хор уршиг үр дагаврын талаар мэдлэг олгох, хууль эрх зүйн боловсролыг дээшлүүлэх зорилгоор 2023 оны 04 дүгээр сарын 05-ний өдөр Нийслэлийн Засаг захиргааны 2-р байрны /Хангарди ордон/ 14 дүгээр давхрын Б танхим болон Төр захиргааны цогцолбор байрны Хурлын танхимд зохион байгууллаа.</p>	100%
13	<p>Төрийн албан хаагчийн ёс зүй болон Удирдлагын ажилтны ёс зүй</p>	<p>Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөц хөгжлийн төвөөс 2023 оны 05 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулсан төрийн албан хаагч бусдыгаа үлгэрлэн манлайлан ажиллах, харилцаа, хандлага, ёс зүйн хувьд мэдрэмжтэй байж бусдыг ойлгон ухаалгаар нөлөөлөх зэрэг дэд сэдвүүдтэй “Удирдлагын ажилтны ёс зүй” сэдэвт сургалтад Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн 4 албан хаагч хамрагдсан.</p> <p>Хүний нөөц хөгжлийн төвөөс 2023 оны 08 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн ёс зүй” сургалтад 3 албан хаагч амжилттай хамрагдсан.</p>	100%
14	<p>Төрийн албан хаагчийн манлайлал</p>	<p>Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөц хөгжлийн төвөөс байгууллагын албан хаагчид өөрсдийн манлайллын ур чадвараа нэмэгдүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, манлайллын арга барилаа сайжруулах аргачлалыг зааж өгөх зорилготой 2023 оны 05 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн манлайлал” сэдэвт 8 цагийн сургалтад байр хариуцсан менежерүүд болон угтах үйлчилгээний ажилтнуудыг хамруулан нийт 22 ажилтан албан хаагчид зохион байгуулсан.</p>	100%

1	2	3	4
15	“Харилцан хүндэтгэе” аян	<p>Жендерийн үндэсний хорооноос Швейцарын хөгжлийн агентлаг, НҮБ-ын Хүн амын сангийн “Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх нь” төслийн дэмжлэгтэйгээр Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Монгол цэргийн өдрийг тохиолдуулан үндэсний хэмжээнд “ХАРИЛЦАН ХҮНДЭТГЭЕ” аянд нэгдэж Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газраас дараах арга хэмжээг зохион байгуулан ажиллалаа. Үүнд:</p> <p>1.“Харилцан хүндэтгэе” нэг сарын аяны хүрээнд Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас 2023 оны 03 дугаар сарын 10-ний өдөр ирүүлсэн 02-02/1322 дугаар албан бичгийн дагуу Нийслэлийн Засаг захиргааны 13 байршилд аяныг зохион байгуулах нэгдсэн төлөвлөгөөг гарган хүргүүлсэн.</p> <p>2.Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын систем <a href="https://erp.ulaanbaatar.mn/">https://erp.ulaanbaatar.mn/</a>-д “Харилцан хүндэтгэе” аянд Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын хамт олон нэгдэж мэдээ мэдээллийг байршуулсан.</p> <p>3.Аяны хүрээнд Нийслэлийн Засаг захиргааны 13 байранд чиг үүргийн дагуу үйлдвэрлэл, үйлчилгээ үзүүлэн ажиллаж байгаа ажилтан, албан хаагчид иргэдийн хөл хөдөлгөөн ихтэй хэсгүүдэд аяны утга санааг агуулсан лого болон 15 төрлийн зурагт хуудсыг иргэдэд зориулсан мэдээллийн самбарт байршуулж, мөн үйлчилгээ авч байгаа нийт 3500 гаруй иргэдэд тараах материалыг тараасан болно.</p> <p>4. Мөн байруудын угтах үйлчилгээний хэсэгт байрлах мэдээллийн самбарт аяны болон Жендерийн эрх тэгш байдлын талаарх богино хэмжээний шторк, мэдээ мэдээллийг байршуулж, нийт 18 аж ахуйн нэгж байгууллага, 1500 төрийн албан хаагчид болон олон нийтэд түгээсэн.</p> <p>5.Эмэгтэй, эрэгтэй хүмүүсийг нийгэмд эзлэх байр суурийг эрх тэгш байлгах, тэгш оролцоог бий болгох зорилгоор байруудад ажиллаж байгаа нийт 270 ажилтан, албан хаагчдад ажлын байранд нь сургалт зохион байгуулж мэдээлэл арга зүйгээр ханган ажиллалаа.</p> <p>6.“Харилцан хүндэтгэе” аяны уриа, мэдээ, мэдээллийг мэдлээллийн самбар, Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний албан ёсны цахим хуудсанд байршуулан, сурталчлан ажилласан.</p>	100%

1	2	3	4
16	Жендэрийн эрх тэгш байдлыг хангахад төрийн албан хаагчийн манлайлал оролцоо	Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газар Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөц хөгжлийн төвтэй хамтран бүх нийтэд хүний эрх, жендерийн боловсрол олгох үндэсний тогтолцоог хөгжүүлэх зорилгоор “Жендэрийн эрх тэгш байдлыг хангахад төрийн албан хаагчийн манлайлал оролцоо” сэдэвт 3 цагийн сургалтыг НЗЗ-ны 5В байрны Иргэний танхимд 2023 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр Хүний нөөц хөгжлийн төвийн сургагч багш С.Нарантуяа удирдан зохион байгууллаа. Тус сургалтад Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс, Үйлдвэрлэл, үйлчилгээний алба, Инженерийн байгууламж ашиглалт, үйлчилгээний албаны нийт 141 албан хаагч хамрагдсан.	100%
<b>Гурав. Эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр</b>			
17	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, журам	Байгууллагын 2023 оны сургалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу нийт албан хаагчдад “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартыг мөрдөх”, “Авлигаас урьдчилсан сэргийлэх” зорилгоор НЗЗ-ны 5 дугаар байрны Иргэний танхимд 2023 оны 04 дүгээр сарын 14-ны өдөр “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй”, “Авлигалын эсрэг хууль, тогтоомжийн хэрэгжилт авлигын хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ” зэрэг сэдвүүдээр сургалт зохион байгуулав.Сургалтад Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс Үйлдвэрлэл, үйлчилгээний алба, Инженерийн байгууламж ашиглалт, үйлчилгээний албаны нийт 152 албан хаагч хамрагдав. Сургалтыг Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн докторант судлаач Г.Эрдэнэтөгс мэдээлэл арга зүйгээр ханган ажиллалаа	100%
<b>Дөрөв. Туршлага солилцох чиглэлээр</b>			
18	Улаанбаатар хотод газар хөдлөлтийн гамшиг тохиолдож, онц байдал тогтоосон үеийн төрийн байгууллагын харилцан ажиллагаа	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Онцгой байдлын газраас “Газар хөдлөлтийн гамшиг”, “Гал түймрийн аюул” сэдэвт сургалтыг гал түймэр, газар хөдлөлтийн аюулаас хэрхэн урьдчилан сэргийлэх талаар мэдлэг мэдээлэл, дадлага олгох зорилгоор 2023 оны 04 дүгээр сарын 06-ний өдөр Нийслэлийн Онцгой байдлын газрын сургалтын танхимд байгууллагын нийт 45 ажилтан, албан хаагчдыг хамруулан зохион байгуулсан.	100%

1	2	3	4
		<p>Сургалтаар газар хөдлөлт, түүний хор уршиг, газар хөдлөлтийн үед яаралтай авах арга хэмжээнүүд, гал түймрээс урьдчилан сэргийлэх, "Галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж"-ийн талаарх мэдлэг, мэдээллийг олгосон. Мөн газар хөдлөлтийн гамшиг тохиолдсон үед авах арга хэмжээ, галын хор болон гал унтраах багаж хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг шалгаж, гал гарсан үед галын хорыг хэрхэн ажиллуулах талаар ажилтан, албан хаагчдад дадлагын хичээл орлоо.</p>	
19	Зөөгчийн мэдлэг олгох онол практик хосолсон сургалт	<p>Зөөгчийн анхан шатны мэдлэг олгох сургалтыг 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдөр 14:00-17:00 цагийн хооронд ,ширээ засах дүрэм Өдөр тутмын ширээ засалт, захиалгат ширээ засалт, Орос, франц, америк, швед үйлчилгээ үзүүлэх аргууд, үйлчлэх аргууд, шилэн эдлэлийн төрөл ангилал, төмөр эдлэлийн төрөл ангилал, дарс болон оргилуун дарсаар үйлчлэх технологи, зочинтой харьцах, ширээ цэвэрлэх, хоолоор үйлчлэх арга техник зэрэг агуулгын хүрээнд Боловсролын шинжлэх ухааны академийн багш Д.Батбямба мэдээлэл арга зүйгээр ханган ажиллалаа.</p>	100%
20	Хууль эрх зүйн сургалт	<p>Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсээс 2023 оны 06 сарын 23-ны өдөр зохион байгуулсан Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын хууль, эрх зүйн ажилтнуудад зориулсан мэргэжил, мэргэшил, арга зүйн зөвлөгөө өгөх бүтэн өдрийн сургалтад тус газраас Хууль эрх зүй тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан ажилтан болон Худалдан авах ажиллагаа, гэрээ хариуцсан ажилтан нар хамрагдсан.</p>	100%
21	БНХАУ-ын худалдааны яамнаас зохион байгуулсан “Дэлхийн хөгжлийн санаачилгын хүрээнд үйлдвэрлэлийн мэдээллийн технологийн хэрэглээ ба менежмент” сургалтанд хамрагдсан.	<p>БНХАУ-ын Худалдааны яамнаас зохион байгуулсан Хөгжиж буй орнуудын хэлтсийн болон түүнээс дээш түвшний холбогдох албан тушаалтнуудад зориулсан Гуйян хотод зохион байгуулагдсан “Дэлхийн хөгжлийн санаачилгын хүрээнд үйлдвэрлэлийн мэдээллийн технологийн хэрэглээ ба менежмент” сургалтад Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын Сүлжээний инженер Б.Жаргалсайхан 2023 оны 06 дугаар сарын 08-21-ний өдрүүдэд оролцсон. БНХАУ-тай</p>	100%

		найрамдалт харилцаатай /Монгол, Лаос, Шриланк, Куба, Гана, Нигер, Узбекистан/ зэрэг 7-н улсын 26 төлөөлөгчид тус семинарт оролцож, мэдээлэл технологи, программ хангамж, сүлжээний технологийн чиглэлээр Экологийн үүл, барилгын материалын үүл, химийн аюулгүй байдлын үүл, ухаалаг хөдөө аж ахуйн үүл, ухаалаг аялал жуулчлалын үүл, хөдөөгийн сэргэлт зэрэг хэд хэдэн үүлэн платформын хэрэглээг Гуйжоугийн Шинжлэх Ухааны академийн сургалтаар танилцаж, хэлэлцсэн.	
22	Бүгд найрамдах Хятад ард улсын Бээжин хотод зохион байгуулагдсан “Цахим худалдааны эдийн засаг” олон улсын сургалтад хамрагдсан.	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн А/127 дугаар тушаалын дагуу 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдрөөс 21-ний өдрийг хүртэлх хугацаанд Бүгд найрамдах Хятад ард улсын Бээжин хотод зохион байгуулагдсан “Digital Economy under the Global Development initiative” буюу “Цахим худалдааны эдийн засаг” олон улсын сургалтад Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын Хурлын заалны зохион байгуулагч Б.Энхбилэгт хамрагдав. Тус семинарт хөгжиж буй 9 улсын /Монгол улс, Гана улс, Ливи улс, Камбожи улс, Узбекистан улс, Бразил улс, Нигер улс, Армани улс, Тринидад ба Тобаго улс/ 9 улсын 20 гаруй төлөөлөгчид тус семинарт оролцож, цахим худалдааны чиглэлээр хэрэгжүүлдэг үйл ажиллагаа, төсөл хөтөлбөр, цаашид хамтарч ажиллах чиглэлийн талаар танилцуулга хийж, хэлэлцсэн болно.	100%

ТАНИЛЦСАН:  
 ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ,  
 САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЗОЛБАЯР

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

ХҮНИЙ НӨӨЦ, СУРГАЛТ  
 ХАРИУЦСАН АЖИЛТАН

А.НОМИНЗУЛ